



**МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД**

14251 Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, Чингисийн өргөн чөлөө 11,
Утас: (976) 51-267168, Факс: (976) 11-312315,
E-mail: info@mrttd.gov.mn, <http://www.mrttd.gov.mn>

2023-03-15 № 01/1118
танай _____-ны № _____-т

Үнэлгээ хүргүүлэх тухай

“МИАТ” ТӨХК-ийн захирлын 2022 оны гэрээний биелэлтийг дүгнэхтэй холбогдуулан Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 184 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн өмчит хуулийн этгээдийн захиралтай онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх журам”-ын 3.11-д заасны дагуу салбарын яамнаас өгөх үнэлгээг хүргүүлж байна.

“МИАТ” ТӨХК-ийн 2022 оны үйл ажиллагааг Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, Сайдын тушаалын биелэлт, Шилэн дансны хөтлөлт, Ил тод байдлын үнэлгээ гэсэн 4 үзүүлэлтээр Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/87 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын дагуу дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр 95,6%-тай буюу 23,9 оноогоор үнэлэгдлээ.

Хавсралт 5 хуудастай.



С.БЯМБАЦОГТ



МИАТ ТӨХК-Д ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭР, САЙДЫН ТУШААЛААР ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТ, ШИЛЭН ДАНСНЫ ХӨТЛӨЛТИЙН БАЙДАЛД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН

2023.01.04

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго

“Монголын иргэний агаарын тээвэр” /МИАТ/ ТӨХК-ийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах замаар яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Төлөвлөсөн арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/87 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг үндэслэл болгосон.

Хоёр. Танилцуулга

“МИАТ” ТӨХК-ийн 2022 оны үйл ажиллагааг Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, Сайдын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт, Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ, Ил тод байдлын үнэлгээ гэсэн 4 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр **95,6%**-тай байна. /Хүснэгт 1/

Эдгээрийг тус тусад нь авч үзвэл:

2.1 Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт:

Нийт заалт	Үүнээс					Биелэлтийн хувь
	100%	70%	30%	0%	Хугацаа болоогүй	
3	1	1	-	-	1	85,0%

Бүрэн хэрэгжээгүй арга хэмжээ:

1/ Ерөнхийлөгчийн зарлиг. 2022-04-05 №43. Засгийн газарт чиглэл өгөх тухай
2. Нийт иргэн, аж ахуй нэгж, байгууллага архи, согтууруулах ундааны хэрэглээ, түүнээс үүдэлтэй эрүүл мэнд, нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагаврыг бууруулахад санаачилгатай оролцох, баяр ёслол, тэмдэглэлт өдөр, ажлын байранд өндөр хатуулагтай этилийн спирт агуулсан архи, согтууруулах ундааг хэрэглэхгүй байхыг уриалсугай.

Биелэлт: Байгууллагын тэмдэглэлт ой, баяр, ёслолын арга хэмжээ, хүлээн авалтад өндөр хатуулагтай этилийн спирт агуулсан архи, согтууруулах ундааг хэрэглэхийг бүрэн хориглосон. МИАТ ТӨХК нь ажилтнуудтайгаа байгуулдаг Хөдөлмөрийн гэрээндээ "Ажлын цагаар болон ажлын бус цагт ажлын байран дээр,



түүнчлэн сургалтанд болон албан томилолтоор ажил үүргээ гүйцэтгэж байх үедээ согтууруулах ундаа хэрэглэхийг хориглон" хөдөлмөрийг гэрээг шинэчлэн байгуулсан. 70%

2.2 Сайдын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилт:

Нийт заалт	Үүнээс						Биелэлтийн хувь
	100%	70%	30%	0%	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
45	41	2	-	-	2	-	98.6

Бүрэн хэрэгжээгүй арга хэмжээ:

1/ Хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай 2019.07.26 №253

1.2. Эрүүл мэндийн үзлэгт зайлшгүй хамруулах шаардлагатай ажилтныг зохих журмын дагуу үзлэгт хамруулан, үзлэгийн мөрөөр эрүүл мэндийг хамгаалж, хөдөлмөрийн нөхцлийг сайжруулан, мэргэжлээс шалтгаалсан өвчлөлөөс урьдчилан сэргийлж, ажилтанд учирч болох эрсдлээс хамгаалсан байх;

Биелэлт: "МИАТ" ТӨХК нь Эрүүл мэндийн сайдын 2014 оны 340 дүгээр тушаалын хавсралтад заасны дагуу эрүүл мэндийн үзлэгийг жилд 1 удаа зохион байгуулдаг. Нислэг үйлдвэрлэлийн нэгжийн нисгэх бүрэлдэхүүний 255 ажилтанг "Гэгээн ар эмнэлэг"-тэй гэрээ байгуулж эрүүл мэндийн үзлэгт 2022 оны 1 дүгээр улиралд багтаан бүрэн хамруулсан. Үлдсэн 542 ажилтанг 2022 оны 4 дүгээр улиралд багтаан Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй эрүүл мэндийн эрт илрүүлгийг "Эх, нярай эмэгтэйчүүдийн үндэсний төв" эмнэлэгтэй хамтран зохион байгуулж ажилтнуудаа үзлэгт хамруулж байна. 2022 онд Эрүүл мэндийн үзлэгт 162,000,000 төгрөг төсөвлөсөн. 70%

2/ Цахим болон тоон гарын үсэгт шилжүүлэх тухай 2020 оны №А/160

1. Төрийн болон албаны нууцад хамаарахаас бусад мэдээ, баримт бичиг, албан хэрэг хөтлөлтийг 2021.01.01-ний өдрөөс тоон гарын үсэгт шилжүүлэн цахимаар мэдээлэл солилцох талаар холбогдох арга хэмжээ авч ажиллахыг харьяа газар, байгууллагуудын дарга, захирал нарт

Биелэлт: "МИАТ" ТӨХК нь 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдөр Цахим гарын үсгийн тухай хууль, холбогдох бусад тогтоол, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны А/160 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах үүднээс тоон гарын үсгийг нэвтрүүлэх зорилгоор цахим гарын үсгийн гэрчилгээ олгогч "Үндэсний дата төв" УТҮГ-тай хамтран ажиллах БА/298 дугаар гэрээ байгуулж, гэрчилгээ авсан. Тоон гарын үсгийг байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлэхээр "Тридум" ХХК-с Э-Токен төхөөрөмжийг худалдан авсан. Тоон гарын үсгийг байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлсэн ажлын тайланг 2022.08.26-ны өдрийн 01/1438 дугаар албан бичгээр ЗТХЯ-нд хүргүүлсэн. 70%

2.3 Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ:

Мэдээлэл	Нийт заалт	Үүнээс					Биелэлтийн хувь
		100%	70%	30%	0%	Хугацаа болоогүй	
Төсөв/гүйцэтгэл	3	3	-	-	-	-	100,0



хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт	5	5	-	-	-	-	100,0
бусад	5	5	-	-	-	-	100,0
Нийт	13	13	-	-	-	-	100,0

2.4 Ил тод, нээлттэй байдлын шалгуур үзүүлэлтүүдийн үнэлгээ:

Мэдээлэл	Нийт заалт	Үүнээс					Биелэлтийн хувь
		100%	70%	30%	0%	Хугацаа болоогүй	
Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээлэл	8	6	1	1	-	-	87,5
Хүний нөөцийн мэдээлэл	6	5	-	1	-	-	88,3
Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээлэл	11	10	1	-	-	-	97,3
Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээлэл	1	1	-	-	-	-	100,0
Бусад мэдээлэл	4	4	-	-	-	-	100,0
Нийт	30	26	2	2	-	-	93,3

Бүрэн хэрэгжээгүй арга хэмжээ:

1/ 1.3. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт, шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж /30%/

2/ 1.9. Хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл /70%/

3/ 2.4. Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам /30%/

4/ 3.1. Өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухай жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл /70%/

Гурав. Үнэлэлт, дүгнэлт

1. Төлөвлөлтийн байдал:

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газартай контрактын гэрээ байгуулахаас гадна компанийн үр ашгийг дээшлүүлэх чиглэлээр бодлогын яамтай хамтран ажиллах гэрээ байгуулан ажлаа дүгнүүлдэг байх зохицуулалтыг бий болгох зөвлөмж өгсөн боловч хэрэгжүүлээгүй байна.

2. Хэрэгжилтийн байдал:

"МИАТ" ТӨХК-ийн 2022 оны үйл ажиллагааг Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, Сайдын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт, Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ, Ил тод байдлын үнэлгээ гэсэн 4 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр 95,6%-тай байна.

Хөгжлийн банкны 15.1 сая ам.долларын зээлийн үлдэгдэл болох 10.2 тэрбум төгрөгийн төлбөрийг Засгийн газрын 220 дугаар тогтоолын дагуу эцсийн хугацаанаас нь 2 сарын өмнө бүрэн төлж барагдуулсан байна.

Дөрөв. Санал, зөвлөмж

1. 2023 онд “МИАТ” ТӨХК-ийн үйл ажиллагааны менежментийг сайжруулан өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, эдийн засаг, санхүүгийн бие даасан, тогтвортой байдал, тээврийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр тодорхой ажлууд төлөвлөн ЗТХЯ-тай хамтран гүйцэтгэлийн төлөвлөгөө батлан ажиллах;
2. Байгууллагын үйл ажиллагааг ил тод нээлттэй байлгах ажлыг тогтмол зохион байгуулж, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Ил тод, нээлттэй байдлын шалгуур үзүүлэлтэд тусгасан мэдээллүүдийг вэб хуудсандаа тогтоосон хугацаанд тогтмол байрлуулах;
3. НТОЗШША-наас гаргасан аюулгүй ажиллагааны зөвлөмжийн хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах, хэрэгжилтийг ИНЕГ, НТОЗШША-д тогтмол тайлагнан ажиллах;

ТАНИЛЦСАН:

САЙД

ДЭД САЙД

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

ИНБХЗГ-ЫН ДАРГА

МИАТ ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ

ХЯНАСАН:

ХШҮДАГ-ЫН ДАРГА

БОЛОВСРУУЛСАН:

ХШҮДАГ-ЫН ШИНЖЭЭЧ

С.БЯМБАЦОГТ

Л.ХАЛТАР

С.БАТБОЛД

Ч.МӨНХТУЯА

Б.МӨНХТАМИР

А.МӨНХБАТ

Д.БАЯРМАА



МИАТ ТӨХК-Д ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭР,
САЙД ТУШААЛААР ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТ, ИЛ ТОД БАЙДАЛ,
ШИЛЭН ДАНСНЫ ХӨТЛӨЛТИЙН БАЙДАЛ

2023.01.04

№	Хяналтанд байх арга хэмжээ	2022 онд төлөвлөсөн нийт арга хэмжээ	Тухайн улиралд төлөвлөсөн арга хэмжээ /Өссөн дүнгээр/	Биелэлт /Хувиар/					Хугацаа болоогүй
				Дундаж хувь	100	70	30	0	
1	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт	3	2	85.0	1	1	-	-	1
2	Сайдын тушаалын биелэлт	45	43	98.6	41	2	-	-	2
3	Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ	13	13	100.0	13	-	-	-	-
4	Ил тод байдлын үнэлгээ	30	30	93.3	26	2	2	-	1
Нийт		91	88	95.6	81	5	2		3